

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

7.1. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт				
Дэд хэсэг	Хийх ажлын агуулга	Шалгуур		Тайлбар
		Гүйцэтгэлийн үзүүлэлт	Оноо 0-70	
7.1.1	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2. 	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/</p>	0-2	<p>Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай зэрэг Монгол улсын хуулиуд, бусад шаардлагатай зарим дүрэм, журмуудыг 2014 оны 8 дугаар сард дүүргийн цахим хуудас болон Тамгын газрын 1 давхарт байршуулсан мэдээллийн самбаруудаар иргэд албан хаагчдад мэдээлэн сурталчилсан. 2014 оны 8 сарын 25-нд www.bgd.mn сайтын ёс зүй авилга цэсэнд Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолын хавсралт ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ, ЖУРАМ-ыг байршуулсан. Мөн “Том төрөөс ухаалаг төр рүү” сургалтыг Тамгын газрын албан хаагчид, харьяа хэлтсийн дарга нарын дунд, “Шилэн данс”-ны өдөрлөгийг дүүргийн нийт хороодын дунд, “Авилга, ашиг сонирхлын мэдүүлэг ба ил тод байдал” сургалтыг Тамгын газрын албан хаагчид, хороодын ажилчдын дунд, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, төрийн байгууллагын ил тод байдал” сургалтыг ИТХ-ын төлөөлөгч, хорооний иргэдийн нийтийн хурлын дарга нарт, “Цагдаагийн албаны хуулийн хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа” сургалт, зөвлөгөөнийг Дүүргийн засаг, орлогч дарга, хэлтсийн дарга нар болон Цагдаагийн 1, 2-р хэлтсийн дарга, албан хаагчдын дунд, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг ба хөрөнгө орлогын мэдүүлэг” сургалтыг нийт албан хаагчдын дунд тус тус зохион байгуулж авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэд болон албан хаагчдад сурталчилан таниулсан.</p>
		<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх</p>		<p>НИТХ-аас 2012 онд гаргасан “Авлигын эсрэг хууль тогтоомжийн эмхэтгэл” 100 ширхэг, АТГ-аас 2014 онд гаргасан “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага” 50 ширхэг, АТГ, Азийн сангаас гаргасан “Амин хувийн ашиг өвсний шүүдэртэй адил, Ард олны ашиг өндөр тэнгэртэй адил” гарын авлага 60 ширхэг, АНУ-ын Азийн сан, Сант Марал сангаас 2014 оны 03 дугаар сард гаргасан “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа”, мөн тус сангаас 2014 оны 7 дугаар сард</p>

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

				гаргасан “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” судалгааны ажлын тайлан болон бусад байгууллагаас гаргасан авлига, ашиг сонирхолын зөрчлийн талаар гаргасан хууль тогтоомж, гарын авлага, материалуудыг Тамгын газрын хэлтэс, албадын дарга, албан хаагч нарт ажлын хэрэгцээнд болон иргэдэд сурталчлан таниулах зорилгоор дүүргийн 23 хороодод тараан хуваарилж Тамгын газрын болон хороодын мэдээллийн самбаруудад байрлуулан сурталчилж ажиллаж байна.
7.1.2	<p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 	<p>Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн га-зар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх</p>	0-3	<p>2013 оны 11 дүгээр сард Нийслэлийн 2014 оны төсвийн хэлэлцүүлгийг дүүргийн нийт иргэдийн дунд зохион байгуулсан ба хэлэлцүүлгийн дүнг Нийслэлийн 2014 оны төсөвт тусгуулахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.</p> <p>2015 оны дүүргийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаарх санал асуулгыг дүүргийн нийт 21 хороо /13, 15 дугаар хороод ИНХ-ын дарга байхгүй гэсэн шалтгаанаар зохион байгуулагдаагүй/-нд зохион байгуулсан ба санал асуулга авах хурал зохион байгуулж хэлэлцүүлэг өрнүүлэн санал авах хэлбэрээр зохион байгуулсан. Улсын их хурлаас батлагдах хуулийн төслийг байршуулж иргэдээс санал авдаг www.parlament.mn, Засгийн газрын www.zasag.mn, www.cabinet.gov.mn цахим хуудсуудын холбоосыг www.bgd.mn цахим хуудсан оруулсан. Мөн Баянгол дүүргийн ИТХ-ын төслийн санал авах хэсэг <i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал-Тогтоолын төсөл</i> хэсэгт байрлаж байна.</p>
		<p>Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх</p>		<p>Улсын их хурлаас батлагдах хуулийн төслийг байршуулсан www.parlament.mn, Засгийн газрын www.zasag.mn, www.cabinet.gov.mn цахим хуудсуудын холбоосыг www.bgd.mn цахим хуудсан оруулсан. Мөн Баянгол дүүргийн ИТХ-ын тогтоолын төсөл www.bgd.mn цахим хуудасны <i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал-Тогтоолын төсөл</i> хэсэгт байрлаж байна.</p>
		<p>Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх</p>		<p>23 хороодод Баянгол дүүргийн шинэчлэлийн багаас 2013 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, төрийн үйлчилгээний шинэчлэлийн ажлын тайлан, 2014 оны ажлын төлөвлөгөөг олон нийтээр хэлэлцүүлэх</p>

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

				уулзалтыг 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ДИТХ-ын дарга Засаг даргын хамтарсан захирамжаар баталсан уулзалт, хурлын нэгдсэн арга хэмжээний хөтөлбөрийн дагуу 23 хороодод 1 дүгээр сарын 9-23-ны өдрийн хооронд зохион байгуулсан.
7.1.3	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах Эрх зүйн үндэслэл: • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3	Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулсан байх	0-3	Засаг даргын Тамгын газрын 2014 оны төлөвлөгөөний 5.3.6-д Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үндсэн болон харьяа хэлтэс, албадын үйл ажиллагааны ил тод байдал, Авлигын эсрэг үйл ажиллагааны тухай оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж өгөхөөр тусгагдсан ба Тамгын газрын төлөвлөгөөг дүүргийн цахим хуудсанд байршуулсан.
		Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/		Дээрх хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг 2014 оны 4 дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн ба 2014 оны 11 дүгээр сарын байдлаар хэлтэс албадаас 2014 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дууссан ба зөвлөмжийг хэлтэс албадад хүргүүлэхэд бэлэн болсон. Эдгээр зөвлөмжүүдийг дүүргийн цахим хуудсанд байрлуулна.
		Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх		Хоёрдогч түүхий эдийн цэгийг нүүлгэх шийдвэр гарсан талаарх сурвалжлагыг тухайн цэг дээрээс нь мэдээлэх ажлыг зохион байгуулж, UBS, ZA, TV10, Olooo, ETV, TV25, NBS, SBN, C1 телевизүүдийн мэдээлийн хөтөлбөрөөр мөн Хурд радио, Нийслэл таймс, Зууны мэдээ сонинд нийтлэгдсэн. “Стрингс”, “Санко”, “Турбо” диско баарнуудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал хүргүүлээ гэсэн мэдээг сайтуудад өгсөн ба нийт 14 сайт, 2 сонинд мэдээ нийтлэгдэж, NTV, MNC, TV25 телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрөөр мэдээлэгдсэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хийгдэж байгаа ажлуудын талаар Засаг даргын орлогч П.Цэцэгмаагийн ярилцлагыг Үндэсний шуудан сонинд бүтэн нүүрээр нийтлүүлсэн. Барс захад гэнэтийн шалгалт хийх явц ETV, ZA телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрөөр мэдээлэгдсэн. NTV телевизтэй хамтран Сэтгүүлчийн эрэл нэвтрүүлгийг бэлтгэж, тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан цэнгээний газрууд болон хууль бус архи, тамхины худалдаанд Цагдаагийн 1, 2 дугаар хэсгүүдтэй хамтран хяналт шалгалт хийж, шаардлагатай мэдээ мэдээллийг бэлтгэн өгч нэвтрүүлэг 2014 оны 04

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

				<p>дүгээр сарын 06-ны өдөр нийтийн хүртээл болсон. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Сэргийлэгч сэтгүүлийг эрхлэн гаргаж, нийт 3 дугаарыг нийтийн хүртээл болгоод байна.</p> <p>Цагдаагийн 1-р хэлтэс, Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэстэй хамтран гэнэтийн шалгалт хийж, ETV, TV8 телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрөөр мэдээлэгдсэн.</p>
7.1.4	<p>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл 	<p>Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/, өм-нөх оны төсвийн гүйцэтгэл, /4 дүгээр сарын 1-ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/-ийг цахим хуудсандаа байршуулах</p>	0-10	<p>Дүүргийн 2014 оны төсөв батлах тухай 16/01, Баянгол дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолыг 2014 оны 06 сарын 18-ны өдөр</p> <p>Баянгол дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 19/01, дүүргийн 2013 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай тогтоолыг 2014 оны 04 сарын 22-нд, Баянгол дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 19/01, дүүргийн 2013 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай тогтоолыг 2014 оны 04 сарын 22-нд, Баянгол дүүргийн 2015 оны ИТХ-ын 19/02, 2013 оны дансны үлдэгдэл зарцуулах тухай тогтоолыг 2014 оны 09 сарын 08-нд</p> <p>Нийслэлийн Аудитын газар:2013 оны Аудитын дүгнэлт 2014 оны 4 сарын 17</p> <p>ИТХ-ын №30, Аж ахуй нэгж байгууллагын хог хаягдал үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох тухай тогтоолыг 2014 оны 09 сарын 08-нд</p> <p>Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар: БГД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн Санхүү үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн тухай 2014 оны 09 сарын 08-нд</p> <p>Нийслэлийн Аудитын газар: Төрийн сангийн тогтолцооны 2013 оны үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн 09 сарын 08-нд</p> <p>Нийслэлийн Аудитын газар: Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт 2014 оны 09 сарын 08-нд</p> <p>БГД-ийн 2015 оны Төсвийн дунд хугацааны төлөвлөгөөний төсөл 2014 оны 09 сарын 08-нд</p> <p>ИТХ-ын дугаар 20/01, 2014 оны төсвийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай 2014 оны 09 сарын 09-нд</p> <p>БГД-ийн 2014 оны орон нутгийн төсвийн зарлагын хуваарь 2014 оны 09 сарын 10-нд</p> <p>БГД-ийн Спорт хороо 2014 оны төсвийн хуваарь 2014 оны 09 сарын 10-нд</p>

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

			<p>БГД-ийн Өрхийн эмнэлэг 2014 оны төсвийн хуваарь 2014 оны 09 сарын 10-нд БГД-ийн Цэцэрлэг 2014 оны төсвийн хуваарь 2014 оны 09 сарын 10-нд БГД-ийн Сургуулийн 2014 оны төсвийн хуваарь 2014 оны 09 сарын 10-нд БГД хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилын 1 сараас 9 сар хүртэлх мэдээг 2014 оны 09 сарын 02-ноос 10 дугаар сарын 27-ны хооронд Сарын төсөвийн орлого гүйцэтгэл, авлага өглөгийн мэдээг хуулийн хугацаанд Шилэн самбарт болон BGD.MN цахим хуудсанд байршуулсан.</p>
		Жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр сарын 1-ний дотор/-г цахим хуудсандаа байршуулах	Дүүргийн 2013 оны төсвийн гүйцэтгэлийг баталсан Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 19/01 тоот тогтоолыг 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр дүүргийн цахим хуудсанд байрлуулсан.
		Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /4 дүгээр сарын 1-ний дотор/-ийг бүрэн эхээр нь цахим хуудсандаа байршуулах	Баянгол дүүргийн 2013 оны санхүүгийн байдлын аудитлагдсан нэгдсэн тайланг 2014 оны 06 сарын 18-ны өдөр, 2014 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Шилэн самбарт болон цахим хуудсанд байршуулсан.
		Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/	2014 оны төсвийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 20/01 тоот тогтоолыг дүүргийн цахим хуудсанд байршуулсан.
		Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/	БГД хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилын 1-9 сар хүртэлх мэдээг 2014 оны 09 сарын 02-ноос 10 дугаар сарын 27-ны хооронд 1-ээс 9 сарын төсвийн орлого гүйцэтгэл, авлага өглөгийн мэдээг хуулийн хугацаанд Шилэн самбарт болон BGD.MN цахим хуудсанд байршуулсан.
		Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас хойш ажлын 14 хоногт багтаан нийтэд мэдээлэх	Монгол улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор 2014 онд Баянгол дүүрэгт концессын гэрээгээр нийт 13 ажил хийгдэхээр тусгагдсан ба эдгээр ажлуудаас 2014 онд концессын гэрээгээр ямар нэгэн ажил хийгдээгүй.
		Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад	

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

		<p>хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/-ийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх</p>	
		<p>Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээ-лэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/-ийг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах</p>	
		<p>Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах</p>	<p align="center">Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаар</p> <p>1. Тэтгэврийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэвэр дор дурдсан төрөлтэй байна:</p> <p>1/ өндөр насны тэтгэвэр; 2/ тахир дутуугийн тэтгэвэр'; 3/ тэжээгчээ алдсаны тэтгэвэр.</p> <p>2. Тэтгэмжийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэмж дор дурдсан төрөлтэй байна:</p> <p>1/ хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж; 2/ жирэмсний болон амаржсаны тэтгэмж; 3/ оршуулгын тэтгэмж</p> <p>Нийгмийн даатгалын шимтгэл төлж ажиллаж байгаа нийт албан хаагчдын нэрсийг www.bgd.mn цахим хуудасны <i>Ил тод байдал-Хүний нөөцийн ил тод байдал</i> хэсэгт байршуулсан.</p>
		<p>Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах</p>	<p align="center">Баянгол дүүрэгт 2014 онд гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй болон хэрэгжихээр төлөвлөгдөж байгаа ажлуудаас "Хааны эрэлд 2014" энхийг дэмжих ажиллагааны хүрээнд АНУ-аас тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийж 114 дүгээр цэцэрлэгийн</p>

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

				<p>сантехникийг бүрэн сольж, гадна хашааг будаж, хүүхдийн тоглоомын талбайг тохижуулсан, Дэлхийн банкны "Боловсролыг дэмжих олон улсын түншлэлийн сургуулийн өмнөх боловсрол" төслийн хүрээнд 12, 19 дүгээр хороонд шинээр баригдаж байгаа 197, 198 дугаар цэцэрлэгийн барилгыг барьсан, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, АНУ-ын Азийн сантай хамтран Загвар хороо хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын иргэдийн санал санаачлагыг дэмжих сангаас 9-р хорооны Далангийн ард иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах үндсэн зорилготой түр уулзах цэг байгуулж, Горькийн 3, 4, 5 гудамжинд өрхийн хог ангилан ялгах хогийн сав суулгах, 30-р гудамжинд 75 метр урттай явган хүний шаталсан зам барих төсөл амжилттай хэрэгжиж дууссан, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Дэлхийн банктай хамтран "Улаанбаатар Цэвэр Агаар Төсөл"-ийн хүрээнд "Тасганы овоо" бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах гэж байгаа энэхүү цэцэрлэгт хүрээлэн нь 1.7 га орчим талбайг хамрах ба 2015 онд ашиглалтанд орохоор төлөвлөгдсөн зэрэг мэдээллүүдийг дүүргийн цахим хуудсаар иргэдэд нээлттэй мэдээлсэн.</p>
7.1.5	<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 	<p>Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрх-лэх зөвшөөрөл/-ийн жагсаал-тыг цахим хуудсандаа байршуулах</p>	0-4	<p>Баянгол дүүргийн ЗДТГ-ын Дэд бүтэц, тохижилтын хэлтсээс "Гадна зах сурталчилгааны байгууламж байрлуулах зөвшөөрөл", "Хоногт 50 хүртэлх тн ус ашиглах зөвшөөрөл"-ийг, Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээс "Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл", "Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл", "Улирлын чанартай худалдаа үйлчилгээний зөвшөөрөл"-ийг, Өмч газрын харилцааны албанаас "Газар эзэмших эрхийг гэрчилгээ"-г тус тус олгож байгаа бөгөөд Баянгол дүүргийн www.bgd.mn сайтын Төрийн үйлчилгээ-Зөвшөөрөл тодорхойлолт хэсэгт дүүргээс олгогддог зөвшөөрлийн тухай мэдээллийг байршуулсан болно.</p> <p>Зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт болон уг асуудлыг шийдвэрлэх журмыг Баянгол дүүргийн www.bgd.mn сайтын Төрийн үйлчилгээ-Зөвшөөрөл тодорхойлолт хэсэгт байршуулсан.</p>
		<p>Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олго-ход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг</p>		

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

		<p>шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах</p> <p>Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах</p> <p>Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох</p>		<p>Баянгол дүүргээс Төв цэнгэлдэх хүрээлэнд баяр наадмын үйл ажиллагааны үеэр худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүсэлт өгсөн аж ахуйн нэгж иргэдийн жагсаалтыг дүүргийн цахим хуудсаар нийтэд ил тод мэдээлсэн.</p> <p>Бусад зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг дүүргийн цахим хуудсанд тавихаар бэлтгэж байна.</p> <p>Хуульд заасан чиг үүргийн дагуух бүртгэлүүд тогтмол хөтлөгдөж байгаа бөгөөд бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах ажил тухай бүрт хийгдэж байгаа.</p>
7.1.6	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл 	<p>Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/</p> <p>Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх</p>	0-2	<p>Төрийн албанд сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах журмыг Төрийн албаны зөвлөлийн цахим хаяг болон дүүргийн цахим хаягтай вэб холбоос хийсэн. Сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулж нөхсөн.</p> <p>2013 онд гарсан сул орон тоон дээр сонгон шалгаруулалт явуулах захиалгыг Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн. Мөн сул орон тоонд дээр төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэй 5 иргэнийг нэр дэвшүүлэхээр тус зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны сонгон шалгаруулалтын талаар Төрийн албан зөвлөлийн www.csc.mn сайтад мэдээлэгддэг.</p> <p>Баянгол дүүргийн www.bgd.mn сайтын <i>Ил тод байдал-Хүний нөөцийн ил тод байдал</i> хэсэгт Тамгын газрын хүний нөөцийн бодлого, хөгжлийн хөтөлбөр болон холбогдох бусад мэдээллийг байршуулан ажиллаж байна.</p>
7.1.7	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p>	<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах</p>		<p>Тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш 1 сарын дотор Худалдан авах ажиллагааны албаны 2014 оны төлөвлөгөөг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төлөвлөх тайлагнах журмын дагуу Сангийн сайдын 264 дугаар тушаалын хавсралт маягт 1-ээр төлөвлөж Дүүргийн Засаг \2014.1.15\ даргаар батлуулсан. Төлөвлөгөөг www.e-procurement.mn сайт болон www.bgd.mn сайтад байршуулсан. Төлөвлөгөөний биелэлт 90%-тай явж байна.2014 оны 4 сарын 1 ний өдөр www.bgd.mn сайтын</p>

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл • Төрийн болон орон нут-гийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5 	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх	0-8	мөрийн хөтөлбөр цэсэнд Дүүргийн Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг байршуулсан.
	Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх		Баянгол дүүргийн www.bgd.mn сайтын нүүр хуудсны <i>Тендер</i> хэсэгт Тендерийн урилгыг тогтмол байршуулдаг. Худалдан авах ажиллагааны журам, олон нийтийн оролцоотой тендер шалгаруулалтын журмыг 04 дүгээр сард оруулсан. Мөн албаны мэдээллийн самбарт байршуулсан.
	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/-ийг цахим хуудсанд байршуулах		Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зарлагдсан 70 ажлын тендерийн урилгыг тухай бүрт нь өдөр тутмын үндэсний шуудан сонинд, www.e-procurement.mn сайт болон үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, бусад мэдээллийн хэрэгслээр нийтэлж зар түгээсэн бөгөөд холбогдох баримтуудыг хавсаргах материалын 16, 17 дахь хэсэгт хавсаргасан болно. Баянгол Дүүргийн www.bgd.mn сайтын нүүр хуудсны <i>Тендер</i> хэсэгт Тендерийн урилгыг тогтмол байршуулдаг бөгөөд нийт 60 ажлын тендерийн урилгыг нийтэлсэн. Зарлагдсан тендерийн гүйцэтгэгчийн талаарх мэдээллийг 2014 оны 09 дүгээр сарын 01-ний байдлаар гаргаж дүүргийн сайтад байршууллаа.
	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулсан байх		Нээлттэй тендерт шалгарсан нийт 70, болон шалгараагүй оролцогчдын мэдээллийг www.e-procurement.mn сайтын үр дүн хэсэгт оруулж шалтгаан нөхцлийг танилцуулан ажиллаж байна. Олон нийтийн оролцоотой тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар зохион байгуулсан 112 тендерийн оролцогчдын шалгарсан болон шалгараагүй тухай шалтгаан нөхцлийг албан бичгээр мэдэгдэн ажиллаж байна.
	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх		Худалдан авсан бараа ажил үйлчилгээний тайлан, мэдээг улирал бүр дүүргийн www.bgd.mn сайтад байршуулан ажиллаж байна.
			ХААА-аас зарласан Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд том оврын автомашин нийлүүлэх тендер 2014 оны 04 сарын 29-ний өдөр зарлагдаж 2014 оны 05 сарын 29-ний өдөр нээгдсэн, Баянгол дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх тендер 2014 оны 04 сарын 29-ний өдөр зарлагдаж 2014 оны 05 сарын 29-ний өдөр нээгдсэн багц тендертэй холбогдох бүх материалыг

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

				<p>Авилгатай тэмцэх газраас 2014 оны 09 сарын 15-ны өдрөөс 7 хоногийн хугацаатай шалгалт хийж, 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдөр тус газраас автомашины тендертэй холбоотой бичиг баримт, тендерийн материалыг эх хувиар нь авсан болно.</p>
		Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах		Худалдан авсан бараа ажил үйлчилгээний тайлан, мэдээг улирал бүр дүүргийн www.bgd.mn сайтад байршуулан ажиллаж байна. Цаашид аудит хийгдсэн тухай дүгнэлтүүдийг тогтмол байршуулан ажиллана. bgd.mn сайтын шилэн данс цэсний тайлан гэсэн хуудсанд улирал бүр байршдаг.
		Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх		“Шинэчлэл үр дүн” ТББ, “Барилгачдын холбоо” ТББ, “Монголын цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллагуудын нэгдсэн холбоо” ТББ зэргийн төлөөлөгчид үнэлгээний хорооны гишүүнээр ажиллаж хөндлөнгийн хяналт тавьж ажилласан байна. Холбогдох материалыг жагсаалтын 20 дахь хэсэгт хавсаргав.
7.1.8	<p>Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 	<p>Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх</p>	0-2	<p>ЗДТГ-ын албан хаагч нарын ажил үүргийн хуваарь ажлын байрны тодорхойлолтыг хийж ажиллахыг дүүргийн Засаг даргын 2013 оны Б/08, А/495 дугаар захирамжаар Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосон ба уг үүргийн дагуу Тамгын газрын даргын 2013 оны 10 дугаар сарын 03-ны Б/349 дугаар тушаалаар нийт 6 хэлтэс, 3 албаны 61 албан тушаалын ажлын байрны тодорхойлолт"-ыг батлуулан дагаж мөрдүүлэн ажиллаж байна. /холбогдох материалыг жагсаалтын 19 дэх хэсэгт хавсаргав./</p>
		Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох		Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдын хариуцсан ажлын байрны зорилго, чиг үүргийг www.bgd.mn сайтын <i>Ил тод байдал- Үйл ажиллагааны ил тод байдал</i> хэсэгт байршуулсан. Мөн удирдлагуудын зураг товч намтар зэргийг дүүргийн цахим хуудсанд байршуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, түүний үндсэн болон харьяа хэлтэс албадын нийт албан хаагчдын нэрс, албан тушаал, ажлын болон гар утасны дугаарыг багтаасан “Ахмадын дэвтэр-2014” гарын авлагыг 50.000 хувь хэвлүүлж дүүргийн бүх өрхүүдэд хороодоор дамжуулан тараасан.

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

7.1.9	<p>Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13; 	<p>Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх /1 ба түүнээс дээш/</p>	0-3	<p>Тендерийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагыг 3 удаа оролцуулж хөндлөнгийн хяналт тавиулсан байна. Хараа хяналтгүй хүүхдүүдэд хувцасны тусламж олгох, хоол хүнсний тусламж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэнийг хамгаалах чиглэлээр “Талита ази” ТББ-тай, ЖДҮДТ-өөс “Мейжик Чойс” сургалтын төвтэй хамтран “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны мэдлэг олгох” сургалтыг хамтран зохион байгуулах зэргээр 21 ТББ, 4 иргэнтэй хамтарч ажиллаж, тодорхой төрлийн үйл ажиллагааг гүйцэтгүүлсэн байна. /холбогдох материалыг жагсаалтын 20 дахь хэсэгт хавсаргав/ Баянгол дүүргийн Нийгэм эдийн засгийн зорилт, Авлигын эсрэг төлөвлөгөөний дагуу Глоб Интернэшнл төв төрийн бус байгууллагатай эрх зүйн шинэтгэл судалгаа, дүн шинжилгээ хийх, хэвлэл мэдээллийн аян зохион явуулах сургалт, бусад арга хэмжээ зохион байгуулах, мониторинг хийх, бусад үр нөлөөтэй аргын талаар харилцан ойлголцох, уулзалтын үе шатанд явж байна.</p> <p>Захиргаа хуулийн хэлтэс Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран 2014 оны 05 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд иргэдэд хууль сурталчлах өдөрлөгийг дүүргийн 20, 23 дугаар хороодод зохион байгуулж явуулсан ба уг ажлын хүрээнд авлигын эсрэг хуулийг сурталчлан ажилласан. Энэхүү арга хэмжээний хүрээнд хичнээн иргэн хамрагдсан талаар Тамгын газрын Захиргаа хуулийн хэлстийн тайлан болон Нийгэм эдийн Засгийн зорилтын биелэлтэд тусгагдсан.</p> <p>Санхүү төрийн сангийн хэлтэс, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвөөс “Мейжик чойс” сургалтын төвтэй хамтран жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 3 сарын 28, 29-ны өдрүүдэд зохион байгуулсан. Мөн 2014 оны 5 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Сангийн яам, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнтэй хамтарсан “Улсын Секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт” сэдэвт сургалтанд нягтлан бодогч нар оролцсон ба дээрх сургалттай холбоотой мэдээллийг www.bgd.mn цахим хуудсанд байршуулсан. 2014.10.19-2014.11.12-ны өдрүүдэд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттай хамтран санхүү төрийн сангийн</p>
	<ul style="list-style-type: none"> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3 	<p>Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх</p> <p>Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх</p>		

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

			<p>мэргэжилтнүүд болон харьяа төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын хамт сургалтанд хамрагдсан байна.</p> <p>Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсээс “Нэг өдрийн танин мэдэхүйн сургалт”, “Амжиргааны баталгаажтх түвшингээс доогуур орлоготой өрхийн хүүхдүүдэд хичээлийн хэрэглэл үнэ төлбөргүй олгох” зэрэг 17 төрлийн үйл ажиллагааг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна. Мөн халуун хоол хөтөлбөрт Төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгжүүдийг шалгаруулан ажиллуулж байна.</p> <p>Дэд бүтэц тохижилтийн хэлтэс нь Баянгол дүүргийн 16-р хорооны 8 дугаар гудамжны зүүн үзүүрт хийх шат хашлагыг 4 иргэнтэй “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан хийж гүйцэтгүүлсэн байна. /тайлан тус бүрийг хавсаргах материалын жагсаалтын 20 дахь хэсэгт хавсаргасан./</p> <p>Дээрх төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, байгууллага, иргэнтэй хамтран ажилласан тухай www.bgd.mn сайт болон Бид Баянголчууд зэрэг сэтгүүлүүдэд мэдээлсэн байна. /хүргүүлэх материалын 21 дэх хэсэгт хавсаргав/</p>
7.1.10	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хууль 6 дугаар зүйлийн 6.1.8; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 	<p>Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх</p> <p>ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх</p>	<p align="center">0-4</p> <p>Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны 10 дугар сарын 16-ны өдрийн “С.Баяржаргалд ажил үүрэг хавсран гүйцэтгүүлэх тухай” Б/419 дугаар тушаалаар Хүний нөөц, хувь хүний хөгжил хариуцсан мэргэжилтэн С.Баяржаргалыг “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, түүнийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үүргийг хариуцуулахаар томилсон. Эрх бүхий албан тушаалтны үүрэг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалингийн 20 хувь, нууцын нэмэгдлийг цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгож байна. /хүргүүлэх материалын жагсаалтын 22 дахь хэсэгт хавсаргав/</p> <p>Эрх бүхий албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг хавсралтаар хүргүүлсэн. /жагсаалтын 23 дахь хэсэгт хавсаргав/</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтанд 2014 оны 09 дүгээр сарын 10-17-ны өдрүүдэд дүүргийн төрийн байгууллагууд болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдлага, холбогдох албан</p>

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

				<p>тушаалтнууд болох хорооны бүх албан хаагч, 20, 47, 51, 13, 28-р сургуулууд, Баянгол дүүргийн багш нар, орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн нийт албан хаагч нарыг хамруулан соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу ажилласан.</p> <p>АТГ /ХШДШХ/-ын үнэлгээ байна. Авлигатай тэмцэх газраас уг тайланг хянасны дараа үнэлэх.</p>
		ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлэх		
7.1.11	<p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл; Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.8, 6.1.6 	<p>Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх</p> <p>Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/</p>	0-6	<p>Засгын газрын 2010 оны 288 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн дагуу "Ёс зүйн хороо байгуулах тухай" Баянгол дүүргийн Засаг даргын 2013.03.14-ний өдрийн А/112 дугаар захирамж гарч, захирамжийг Тамгын газрын бүх ажилтан албан хаагчдад танилцуулан гарын үсэг зуруулсан. /жагсаалтын 24 дэх хэсэгт хавсаргав./</p> <p>Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой мэдээллийг www.bgd.mn цахим хуудасны <i>Ил тод байдал- Иргэдийн дуу хоолой</i> булан, <i>Төрийн үйлчилгээ- Өргөдөл, гомдол, санал хүсэлт</i> буланд нээлттэй хүлээн авдаг. Мөн Тамгын газрын Иргэдийн өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн Д.Гэрэлээ цахим шуудан, утсаар, бичгээр болон биечлэн хүлээн авч байна.</p> <p>2013 онд Ёс зүйн хорооны 4 удаагийн хурлаар 7 албан хаагчид сахилгын арга хэмжээ авагдсан бол 2014 онд 4 удаагийн хурлаар 3 албан хаагчид арга хэмжээ авагдсан ба шийдвэрүүдийг жагсаалтын 25 дах хэсэгт хавсаргасан. Ёс зүйн дүрмийн дагуу арга хэмжээ авагдсан албан хаагчдын талаар Тамгын газрын ажилчдын хурал болон хэлтэс, албадын хуралд мэдээлэл хийж ажилласан. "Төрийн захиргааны албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийн хянан шийдвэрлэх журам"-ыг www.bgd.mn цахим хуудасны <i>Ил тод байдал-Ёс зүй, авилга</i> хэсэгт байршуулсан.</p>
		Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл / <i>тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлсэн байх</i>		
		Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах		
		Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх		
		Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх		

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

7.1.12	<p>Давхар ажил эрхлэх боломж-той эсэхийг шийдвэрлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл 	<p>Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх</p> <p>Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх</p>	0-2	<p>Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг 2014 онд гаргасан ба албан хаагчдад уг жагсаалтыг танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулсан./жагсаалтын 26 дахь хэсэгт хавсаргав./</p> <p>Давхар ажил эрхлэлтийн судалгааг 2014 онд хийсэн ба уг судалгаагаар давхар ажил эрхэлдэг албан хаагч одоогийн байдлаар байхгүй байна.</p>
7.1.13	<p>Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5 	<p>Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/</p> <p>Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах</p> <p>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах</p> <p>Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах</p>	0-4	<p>Дүүргийн www.bgd.mn цахим хуудсын <i>Тогтоол, шийдвэр, захирамж</i> хэсэгт дүүргийн удирдлагуудаас гаргасан шийдвэрүүдийг нийтэд мэдээллэн ажиллаж байгаа ба 2014 онд Нийслэлийн нутгийн Захиргааны байгууллагуудаас гаргасан шийдвэрийн нэгдсэн санг багтаасан www.ublegal.mn цахим хуудсанд 1969 оноос 2014 онд гарсан нийт шийдвэрүүдийг байршуулах ажил хийгдэж байна.</p> <p>Дүүргийн Засаг даргын нийт захирамжийн 10 орчим хувь буюу нийтэд чиглэсэн мэдээллийн чанартай болон нууцад үл хамаарах захирамжуудыг шат дараалалтайгаар дүүргийн www.bgd.mn цахим хуудсны <i>Тогтоол, шийдвэр, захирамж</i> хэсэгт байрлуулан ажиллаж байна.</p> <p>Дүүргийн Засаг дарга болон түүний Тамгын газар, үндсэн болон харьяа хэлтэс, албадын үйл ажиллагаанд Монгол Улсад мөрдөгдөж байгаа бүхий л хууль дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөл эдгээрийн дотроос голчлон хэрэглэдэг 140 орчим хуулийг дүүргийн цахим хуудсанд системчлэн байрлуулахаар ажиллаж байна.</p> <ol style="list-style-type: none"> Баянгол Шинэ-Өргөө ОНӨААТҮГ нь Аж ахуй нэгж байгууллагаас төлөх хог хаягдлын хураамж ХҮҮХ-ээс Тамхи худалдах тусгай зөвшөөрөл ААНБ, иргэнд шинээр олгох болон сунгах, ХҮҮ эрхлэх гэрчилгээ олгох, түр худалдаа эрхлэгчдийн зөвшөөрөл олгох зэрэг ДБТХ- Гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулах зөвшөөрлийн төлбөр, СӨХ-ийн гэрчилгээний тэмдэгтийн хураамж ХААА- Тендерийн баримт бичгийн үнэ

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

				5. Усан спорт сургалтын төв- Сургалтын төлбөрийг тус тус үйлчлүүлэгчээс авдаг төлбөр хураамжийн жагсаалтыг хүргүүлэх материалын 30 дах хэсэгт хавсаргасан бөгөөд www.bgd.mn цахим хуудасны <i>Төрийн үйлчилгээ-Зөвшөөрөл тодорхойлолт олгох</i> хэсэгт байршуулсан.
7.1.14	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах Эрх зүйн үндэслэл: <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3; • Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг 	Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр) Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх	0-4	Дүүргийн Засаг дарга болон түүний Тамгын газар, харьяа хэлтэс албадын үндсэн үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг дүүргийн цахим хуудсанд байрлуулсан нь хууль тогтоомжоор хүлээсэн эрхлэх асуудлын хүрээг харуулж байгаа ба цаашид дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хуулиудыг нэгтгэн байршуулснаар бүрэн мэдээлэгдэнэ. Дүүргийн Засаг дарга болон түүний Тамгын газраар үйлчлүүлж төрийн үйлчилгээг авч байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд өргөдөл, гомдол, санал, хүсэлтээ нийслэлийн шууд утаснууд буюу 12-00, 11-11 зэрэг дугаарын утас, мөн дүүргийн өргөдөл гомдол хүлээн авах албан тушаалтанд амаар болон бичгээр гаргах, дүүргийн Засаг даргын иргэдийг хүлээн авах өдрөөр болон уулзалт ярилцлага, хэлэлцүүлэг тайлангийн үеэр гарган хуулийн хугацаанд шийдвэрлүүлэх эрхээр нээлттэй ханган ажиллаж байна. Мөн www.smartcity.mn , www.bgd.mn цахим хуудсуудаар өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах боломжтой. Иргэд, байгууллагын өргөдөл, санал, гомдол, хүсэлт хариуцсан мэргэжилтэн Д.Гэрэлээгийн албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг www.bgd.mn цахим хуудасны <i>Төрийн үйлчилгээ-Өргөдөл гомдол санал авах</i> хэсэгт байршуулсан. Дүүргийн иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэхээр ажилладаг ба эдгээрээс нэг бүрчлэн шууд шийдвэрлэх боломжгүй өргөдөл, хүсэлт, гомдлыг нэгтгэн шийдвэрлэх тохиолдлууд гардаг. Үүнд: дээврийн их засвар, зам засвар, тохижилтын ажил, лифт засвар зэрэг хөрөнгө оруулалт ихээр

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

				шаардсан ажлуудыг нэгтгэн шийдвэрлэх тохиолдол байдаг ба энэ талаар дүүргийн цахим хуудас, сар, улирлаар хэвлэгдэн гардаг дүүргийн тайлан, мэдээллийн сонин сэтгүүлүүдээр мэдээллэгддэг болно. Захидал харилцаа, өргөдөл гомдол хариуцсан албан хаагч нарын хариуцсан албан тушаалын нэр, овог нэр, утасны дугаарууд, иргэд өргөдөл гомдлоо хэрхэн гаргах талаар тайлбар, заавар болон Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль зэргийг дүүргийн цахим хуудсанд дэлгэрэнгүй нийтэд ойлгомжтой байдлаар тавьж иргэдээс санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч ажиллаж байна. Иргэдийн өргөдөл гомдол, санал, мэдээлэл, хүсэлтийг шийдвэрлэсэн байдлыг “Бид Баянголчууд” сэтгүүл, “Баянголын мэдээ”, “Нийгмийн шуудас сонин”, Нийслэл таймс”, “Үндэсний шуудан” сонин, “Монголын мэдээ”, “Зууны мэдээ”, “Өнөөдөр” сонин, “Улс төрийн тойм” сонин, Eagle TV, ETV, UBS, TV8, ZA TV, Royal TV, Эх орон зэрэг телевизүүдээр тус тус мэдээллэсэн./холбогдох материалыг жагсаалтын 32 дах хэсэгт хавсаргав./
7.1.15	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 	<p>Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх</p>	0-2	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хэлтсүүдийн албан хаагч нарын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь, албан хаагч нарын үйл ажиллагаанд хамаарах хууль, дүрэм, журмыг судласны үндсэн дээр дүүргийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хэлтсүүдийн албан хаагч нарын дундаас авлигад өртөх эрсдэлтэй албан хаагчдын судалгааг гаргасан ба энэхүү судалгаагаар нийт авлигад өртөх эрсдэлтэй 44 албан хаагчийн жагсаалт гарсан./холбогдох материал, судалгааг жагсаалты 34 дэх хэсэгт хавсаргав/</p>

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

		Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/		Тамгын газрын сургалт арга хэмжээний жилийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхолын зөрчлийн талаарх сургалтуудыг АТГ-ын сургалтын хуваарьт төлөвлөгөөтэй уялдуулан оруулсан ба төлөвлөгөөний дагуу 2014,3,19-нд “Авлига, ашиг сонирхлын мэдүүлэг ба ил тод байдал” сэдвээр, 2014-04-09 нд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, төрийн байгууллагын ил тод байдал” сэдвээр, 2014-06-12 нд “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг” сэдвээр, 2014-10-10-17 өдрүүдэд нийт 4 сургалтанд Тамгын газрын болон хороод, харьяа алба хэлтсүүдийн нийт албан хаагчдийг хамруулсан. Авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр БГД-ийн ЗДТГ-ын даргын тушаалаар 23-р хорооны нийгмийн ажилтан Ш.Аригмааг 11-р хорооны зохион байгуулагчаар, 11-р хорооны нийгмийн ажилтан М.Цэцгээ 17-р хорооны нийгмийн ажилтнаар тус тус сэлгэн ажиллуулав. Мөн нийт хэлтсийн дарга нар, албан хаагчидтай “Ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах” гэрээ байгуулан ажиллуулж байна. /жагсаалтын 34 дэх хэсэгт хавсаргав/
7.1.16	Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно. Эрх зүйн үндэслэл: <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 		0-1	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд Төрийн өмчийн хороо болон аймаг, нийслэлийн ИТХ-аас төрийн болон орон нутгийн өмчийн байранд түрээсийн гэрээгээр байрлаж буй байгууллага байхгүй болно.
7.1.17	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гарга-сан шийдвэрийг биелүүлэх Эрх зүйн үндэслэл:	АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ		АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдэл байхгүй болно.

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

	<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 	<p>Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ</p> <p>АТГ-аас зөрчил арилгуула-хаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион бай-гуулсан арга хэмжээ</p> <p>АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт</p> <p>Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх</p>	<p align="center">0-10</p>	<p>2014 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 05/8376 тоот “Хуулийн хэрэгжилтийг хангах” тухай албан бичгийг хүлээн авч дурдсан зөрчлүүдийг арилгаж хариуг 2014 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 06/2734 тоот албан бичгээр хүргүүлсэн.Тус албан бичигт Нийтийн албанд нэр дэвшигч нийтийн болон хувийн ашиг сонирхолын уьдчилсан мэдүүлэг хянуулаагүй томилогдсон /хороод хооронд сэлгэн ажилласан болон хэлтэс дотроо албан тушаал өөрчлөгдсөн./ 11 албан хаагчийг 2014 оны 10 дугаар сарын 15-ны Б/25 тоот захирамж, Б/416 тоот тушаалаар ажлаас чөлөөлөн, томилогдсон тушаал, шийдвэрийг хүчингүй болгож, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлж АТГ-ын 2014 оны 10 дугаар сарын 20 –ны өдрийн 05/8719 тоот албан бичгээр Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулан зөрчлийг арилгах арга хэмжээ авлаа. Цаг үеийн шаардлагаас хамааран /2014 оны 2 дугаар улирлын цэрэг татлагатай холбогдуулан / үлдсэн 23 н хороодын Засаг дарга нарын урьдчилсан мэдүүлгийг дараагийн шатанд хянуулахаар арга хэмжээ авч ажиллаж байна.</p> <p>Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд том оврын автомашин нийлүүлэх тендер 2014 оны 04 сарын 29-ний өдөр зарлагдаж 2014 оны 05 сарын 29-ний өдөр нээгдсэн. Тус тендерт гүйцэтгэгчээр шалгарсан компаний зөвлөмжийг ирүүлсэний дагуу Тарант ХХК-тай 2014 оны 06 сарын 20-ны өдөр гэрээ байгуулан машиныг хүлээн авсан. Машиныг хүлээн авсаны дараа Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн 2014 оны 07 сарын 01-ний өдөр 20-5/1079 тоот бүхий албан бичгээр тус компани нь Татварын хэлтэст 60,7 сая төгрөгийн өртэй болох нь тогтоогдож худалдан авах ажиллагааны албанаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.6 дэх заалтын дагуу зөрчил гаргасан гэж үзэн 2014 оны 06 сарын 10-ний өдрийн ирүүлсэн зөвлөмжийг хүчингүй болгох албан бичиг ирүүлсний дагуу гэрээг цуцалсан.</p>
--	---	---	----------------------------	---

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

				<p>Баянгол дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх тендер 2014 оны 04 сарын 29-ний өдөр зарлагдаж 2014 оны 05 сарын 29-ний өдөр нээгдсэн. Худалдан авах ажиллагааны албанаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу Билгүүн транс ХХК-тай 2014 оны 06 сарын 23-ний өдөр гэрээ байгуулан 2014 оны 06 сарын 30 өдөр тус автомашиныг хүлээн авсан.</p> <p>Автомашиныг хүлээн авсаны дараа ашиглагч байгууллага болох Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тус автомашиныг ашиг сонирхлын зөрчил үүсгэх тул гэрээг цуцалж өгнө үү гэсэн албан бичиг ирүүлсэний дагуу Тамгын газрын даргын 2014 оны 10 сарын 14-ний өдрийн А/258 тоот тушаалаар гэрээг хүчингүй болгож Билгүүн транс ХХК-д гэрээг цуцлагдсан албан бичгийг хүргүүлсэн.</p> <p>ХААА-аас зарласан тус багц тендертэй холбогдох бүх материалыг Авилгатай тэмцэх газраас 2014 оны 09 сарын 15-ны өдрөөс 7 хоногийн хугацаатай шалгалт хийж, 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдөр тус газраас автомашины тендертэй холбоотой бичиг баримт, тендерийн материалыг эх хувиар нь авсан болно.</p>
		<p>АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ</p>		<p>Мөн ХАС,ХОМ-ийг хугацаа хожимдуулж өгсөн 31 албан тушаалтнуудыг ёс зүйн хороогоор авч хэлэлцэн сануулах сахилгын арга хэмжээ авлаа.</p>
7.2.Авилгатай тэмцэх санал, санаачилга				
Дэд хэсэг	Хийх ажлын агуулга	Шалгуур	Тайлбар	
		Гүйцэтгэлийн үзүүлэлт	Оноо 0-30	

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

7.2.1	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэм-жээг боловсруулж хэрэгжүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2; 	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх</p> <p>Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх</p> <p>Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа /жил бүрийн 11 сарын 15-ны дотор/-нд АТГ-т хүргүүлсэн байх</p> <p>Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх</p>	0-5	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг 2014 оны 03 дугаар сарын 05-ны өдөр дүүргийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж байна.</p> <p>Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай явагдаж байна.</p> <p>Дүүргийн 2014 онд баталсан төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх шинэчилсэн загвар хоёрын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт зөрүүтэй байгаа нь ажлын ачаалал, цаг хугацаа алдагдуулахад хүргэж байна. Иймд шинэчилсэн загварыг оны эхэнд төлөвлөгөө батлуулахад хавсарган өгч байвал ажлын ачаалал, цаг хугацаа хэмнэсэн арга хэмжээ болохоор байна.</p> <p>Авлигын эсрэг төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нийт албан хаагчид авлигатай тэмцэх урьдчилан сэргийлэх, соён гэгээрэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн.</p>
7.2.2	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга		Баянгол дүүргийн Нийгэм эдийн засгийн зорилт, Авлигын эсрэг төлөвлөгөөний дагуу “Глоб Интернэшнл төв” төрийн бус байгууллагатай эрх зүйн шинэтгэл судалгаа, дүн шинжилгээ хийх, хэвлэл мэдээллийн аян зохион явуулах сургалт, бусад арга хэмжээ зохион байгуулах, мониторинг хийх, бусад үр нөлөөтэй аргын талаар

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

		/уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал	0-15	харилцан ойлголцох, уулзалтын үе шатанд явж байна. Дүүрэгт ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэн ажиллах тухай дүүргийн сайтад 2014-01-27 тавигдсан.“Шилэн данс” өдөрлөгийг 2014-03-31-нд 4 дүгээр хорооноос эхлүүлэн 2014-10-02 нд бүх хороодод зохион байгууллаа. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг 2014 оны 03 дугаар сарын 05- ны өдөр батлуулсан. Bgd.mn сайтны мөрийн хөтөлбөр цэсэнд 2014 оны 03 сарын 05 ны өдөр байршуулсан.
		Удирдах алба тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилга, тэдний үлгэр жишээ байдал		Дүүргийн Засаг даргын санаачлага, захирамжаар авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх талаар сургалтууд зохион байгуулагдсан. Тус тайланг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн жагсаалтын 2 дахь хэсэгт холбогдох материалуудыг хавсаргав.
		Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/		Авлигын эсрэг үйл ажиллагаа, арга хэмжээ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүрээнд зохион байгуулагдсан сургалтын зардалд нийт 298 000 төгрөгийн төсвийн зарцуулалт хийсэн ба зарцуулалтын тайланг хүргүүлэх материалын 38 дахь хэсэгт хавсаргасан.
		Удирдлагын хүсэл, эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлын талаар ажилтнуудаас өгсөн үнэлгээ		Нийт ажилчин, албан хаагчдын зүгээс удирдлагуудын авлигын талаар авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээнд сэтгэл дүүрэн байж чаддаг бөгөөд удирдлагуудын хүсэл эрмэлзэл, хүчин чармайлтанд сайн үнэлгээ өгч дэмжиж ажилладаг.
7.2.3	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэг-дүүлэх	Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх		Дүүргийн Тамгын газрын хэлтэс албадын АТГ-тай харилцах эрх бүхий албан тушаалтан болон хэлтэс албадын удирдлагууд, мэргэжилтэнүүдэд АТГ-ын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн мэргэжилтэн Б.Нанжидгүндэлмаа, Д.Балдандоржтой

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

		сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах	0-10	<p>хамтран “Авлига, Ашиг сонирхлын зөрчил ба ил тод байдал”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, төрийн байгууллагын ил тод байдал” сэдэвт сургалтыг 2014.03.19, 2014.04.09-ны өдрүүдэд зохион байгуулсан. Мөн “Том төрөөс ухаалаг төр рүү” сургалтыг Тамгын газрын албан хаагчид, харьяа хэлтсийн дарга нарын дунд, “Шилэн данс”-ны өдөрлөгийг дүүргийн нийт хороодын дунд , “Авилга, ашиг сонирхлын мэдүүлэг ба ил тод байдал” сургалтыг Тамгын газрын албан хаагчид, хороодын ажилчдын дунд, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, төрийн байгууллагын ил тод байдал” сургалтыг ИТХ-ын төлөөлөгч, хорооний иргэдийн нийтийн хурлын дарга нарт, “Цагдаагийн албаны хуулийн хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа” сургалт, зөвлөгөөнийг Дүүргийн засаг, орлогч дарга, хэлтсийн дарга нар болон Цагдаагийн 1, 2-р хэлтсийн дарга, албан хаагчдын дунд, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг ба хөрөнгө орлогын мэдүүлэг” сургалтыг нийт албан хаагчдын дунд тус тус зохион байгуулж авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэд болон албан хаагчидад сурталчилан таниулсан.</p> <p>“Ахмадын дэвтэр” гарын авлага 50.000 хувь хэвлүүлж дүүргийн бүх оршин суугчдын гэрээр хороодоор дамжуулан тараасан. Уг гарын авлагад Дүүргийн ИТХ-ын тэргүүлэгч нар болон ЗДТГ-ын нийт ажилтнуудын албан тушаал, утасны дугаарыг хэвлэсэн. Дүүргийн цахим хаягт ТГ-ын албан хаагчдын албан тушаал , утасны дугаар, нэр, хаягийг 2014 оны 9 дүгээр сард байршуулсан Захиргаа хуулийн хэлтсээс хүсэлт гаргасаны дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2014 оны 05 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд иргэдэд хууль сурталчлах өдөрлөгийг дүүргийн 20, 23 дугаар хороодод зохион байгуулж явуулсан ба уг ажлын хүрээнд авлигын эсрэг хуулийг сурталчлан ажилласан.</p>
		Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ		

**Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны
Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт**

		Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ	+10	Дотоод аудитын албаны хяналт шалгалтын явцад ашиг сонирхлын зөрчил илрээгүй.
		Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ	-5	Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил байхгүй байна.
		Шүүхээр шийдэгдсэн Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчил	-5	Шүүхээр шийдэгдсэн болон Авлигатай тэмцэх газрын шалтгалтаар илэрсэн гэмт хэрэг болон авилгын зөрчил байхгүй байна.

Хянасан:

Тамгын газрын дарга

Т.Нямцэцэг

Боловсруулсан:

Хүний нөөц, хувь хүний хөгжил,

ХАС, ХОМ хариуцсан мэргэжилтэн

С.Баяржаргал